

лагыг сайтар мэдэрч байх нь онц чухал. Гэвч тэдгээр нь аюулгүй байдлын бодлогод нөлөөлөх зөвхөн гадаад талын хүчин зүйлүүд болохоос биш дангаараа аюулгүй байдлын бодлого бус, Үндэсний аюулгүй байдлын бодлого гэдэг бол чухамдаа дээрх таван чиглэлийг зангидагч ухаалаг, уян хатан дипломат үйл ажиллагаа юм. Энэ утгаараа дипломат үйл ажиллагаа бол аюулгүй байдлын бодлогын төвлөрсөн илэрхийлэл мөн. Эндээс үзвэл таван төрлийн, дипломат үйл ажиллагаа, тухайлбал, ардчиллын, олон сурвалжит, олон улсын эрхийн, эдийн засаг, технологийн, соёл иргэншлийн дипломат үйл ажиллагаа хэрэгтэй болж байна. Эдгээр таван төрлийн дипломатыг бие биеэс нь салгах аргагүй. Тэднийг хооронд нь нягт уялдуулан, цогцолбороор явуулах ёстой. Монголын дипломатын энэхүү цогцолбор шинж хэдийчинээ сайн хангагдана, Монгол улсын аюулгүй байдал төдийчинээ бэхжинэ.

## **БЭЭЖИН-ТАЙБЭЙ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА**

**С. Энхбаяр\***

«Тайваны асуудал» хэмээх нэр томъёо үүссээр дөч гаруй жилийн нүүр үзэж байгаа бөгөөд энэ асуудал хэрхэн бий болсныг шууд хэлэхийн урьд тайван арлын үүх түүхээс цухас дурдах хэрэгтэй юм.

Тайван арал нь эртнээс янз бүрийн улс гүрний анхаарлыг татсаар иржээ. Европчуудаас анх түрүүн португальчууд XVII зууны сүүлээр уг арал дээр очиж, үзэсгэлэн сайхныг нь бахдан «Ilina Formosa» буюу «Гайхамшгийн сайхан орон» гэдэг нэр өгсөн юм. Үүнээс хойш Тайван арал нь испани, голландчуудын эзэмшилд ээлжэн орсон ба 1661 онд Хятадын Фузянь мужийн бүрэлдэхүүнд багтан, улмаар 1886 онд Циний эзэнт улсын тусгаар мужийн статустай болжээ. Гэвч Хятад-Японы дайны дараа Симоносекийн гэрээгээр (1895. IV. 17) тус арал япончуудын мэдэлд шилжжээ. Тухайн үед Тайван арлын захирагчаар томилогдсон Гото Симпэй гэгч арлын эдийн засаг, улс төрийн ач холбогдлыг тодорхойлж: «Хэрэв Японы Засгийн газар арлыг колоничлох ажлыг гүйцэтгэж чадвал арал манай цаашдын агуу их төлөвлөгөөг хэрэгжүүлэх бааз болно. Эндээс Филиппин холгүй ба өмнөд тэнгисийн арлуудыг дамжин Гонконг, Аннам, Сингапурт, хүрэхэд дөхөмтэй. Энэ бүгд Японы эзэнт улсын захиргаанд орох ёстой. Гэхдээ энэ нь ирээдүйн хэрэг бөгөөд Тайван нь түүний баталгаа болно<sup>1</sup> гэж хэлж байжээ. Дэлхийн II дайны ид дундуур Кайрт АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Их Британийн ерөнхий сайд У.Черчилль, Гоминьданы засгийн тэргүүлэгч Чан Кайши нар уулзаж (1943. XI. 22—26), хамтарсан тунхаглал гаргасан бөгөөд Тайваны талаарх Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрчээ. Хожим 1945 онд 3 их гүрний Потсдамын бага хурал энэ шийдвэрийг бататгасан бөгөөд Япон үг дуугүй бууж өгсний дараа Тайван арал дахин Хятадын мэдэлд шилжсэн юм. НҮБ 1949 оны 12-р сарын 8-нд гаргасан тогтоолдоо Тайван Хятадад маргаангүй хамаарагдахыг хүлээн зөвшөөрчээ.

Хятадыг чөлөөлөгдсөний дараа Хятадын улс төрийн хоёр том хүчин-Гоминьдан болон ХКН-ын хоорондын зөрчил улам хурцадсаар иргэний дайнд хүрсэн бөгөөд уг дайнд ялагдсан гоминьданы талынхан 1949 онд Тайван арал дээр зугтан гарснаар «Тайваны асуудал» гэгч

\* МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн хятад судлалын 1 ангийн оюутан,

бий болсон билээ. Энэ үеэс эхлэн 80-аад он хүртэл хоёр тал дайны байдалтай явж ирсэн бөгөөд харин сүүлийн жилүүдэд хоёр талын харилцанд ихээхэн ахиц дэвшил гарч байна. БНХАУ болон Тайваны засаг захиргаа хагарал зөрчлийг арилгах талаар сүүлийн арав гаруй жил хийсэн янз бүрийн алхам, хоёр талын харилцааны өнөөгийн төвшин, хойшдын төлөвийг судлахын тулд засаг захиргааны бодлого, үйл ажиллагааг соргоогоор ажиглан дүгнэхийн зэрэгцээ тухайн асуудалд бүс нутагт нөлөөтэй их гүрнүүд хэрхэн хандаж буйг харгалзан үзэх нь зайлшгүй чухал юм. Иймд энэ гурван хүчин зүйлийг тус тусад нь авч үзье.

### **«Тайваны асуудал»-д хандах БНХАУ-ын байр суурь**

Иргэний дайнд ялагдсан гоминьданы үлдэгдэл Тайван арал дээр дутаан очсоноос хойш БНХАУ «Тайваныг чөлөөлөх» буюу асуудлыг шийдвэрлэхэд зэвсгийн хүч хэрэглэх бодлогыг тууштай баримталсаар ирсэн юм. Үүнд тухайн цаг үеийн байдал, хүйтэн дайн ид өрнөж байсан зэрэг нь нөлөөлсөн биз ээ. 70-аад оны сүүлчээс БНХАУ-ын удирдлага дипломат бодлогоо үндсээр нь өөрчилж, уян хатан шинжтэй болгосон нь Тайванд хандах хандлагад нь ч нөлөөлжээ. 1979 оны 1-р сарын 1-нд БХАТИХ-ын Байнгын хорооноос Тайван дахь эх орон нэгтнүүддээ хандаж уриалга гаргасан юм. Энэ нь хоёр талын харилцааг эерүүлэхэд шууд чиглэсэн бөгөөд уриалгад «ХАЧА энэ өдрөөс эхлэн Зиньмэнь болон бусад арлыг бөмбөгдөхөө зогсооно»<sup>2</sup> гэж заажээ. Мөн оны 1-р сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Дэн Сяопин АНУ-д айлчлахдаа Америкийн конгрессын гишүүдийн өмнө: «Бид цаашид «Тайваныг чөлөөлөх» гэдэг нэр томьёо хэрэглэхгүй»<sup>3</sup> хэмээн мэдэгдсэн байна. Ийнхүү Тайваны асуудлыг энх тайвны замаар шийдвэрлэх үндэс суурь тавигдсан юм. Удалгүй «Нэг улс, хоёр систем» зарчмын хүрээнд Тайваныг энх тайвнаар нэгтгэх үзэл баримтлал ар араасаа гарч ирсэн бөгөөд эдгээрийн гол санаа нь Тайван нэгдвэл засаг захиргааны онцгой нэгж болгон, Нийгэм-эдийн засгийн байгууллыг нь хэвээр үлдээх бөгөөд гагцхүү олон улсын тавцан дээр БНХАУ л Хятадыг төлөөлөх ёстой гэдэгт оршино. Үүний хамт БНХАУ 1972 оны 2-р сарын 28-нд АНУ-тай хамтран гаргасан Шанхайн тунхаглалд заасанчлан «Нэг Хятад, нэг Тайван», «Нэг Хятад, хоёр засаг», «Хоёр Хятад» зэрэг бодлогыг хүлээн зөвшөөрөхгүй<sup>4</sup> гэдгээ давтан мэдэгдэж байгаа юм.

Ийнхүү БНХАУ-ын зүгээс нааштай алхам хийж буй ч Тайваны эрх баригчдын явуулж буй «гурван үгүй» бодлогын улмаас улс төрийн төвшинд шууд яриа хэлэлцээ одоо хүртэл хийгдээгүй байна. Харин эдийн засгийн харилцаа нь өргөжин, хамтын ажиллагааны хэлбэрт улам бүр шилжиж байгаа билээ. Тайванаас хөрөнгө оруулагчдад нэн таатай нөхцөл бүрдүүлсний дунд 1990 оны эцэс гэхэд БНХАУ-д Тайваны 2000 гаруй компани, пүүс ажиллаж байна. Өнгөрсөн онд Тайван, Сянган хөрөнгө оруулагчид Хятадад 68 сая 980 мянга орчим долларын өртөг бүхий 110 орчим үйлдвэр байгуулахаар гэрээ хийжээ<sup>5</sup>. Урьдчилсан мэдээгээр 2 талын худалдаа өнгөрсөн онд 5 тэрбум долларт дөхсөн байна. Иргэд харилцан зорчих нь олширч, ялангуяа Тайванаас ирэгсдийн тоо жилд хэдэн зуун мянгад хүрэх болов. Зөвхөн - 1987-1989 онд Тайванаас эх газрын Хятадад 800 мянга орчим хүн иржээ. Харин Хятадаас Тайванд очсон хүмүүсийн тоо тун цөөн байна.

БНХАУ-аас Тайваны талаар цаашид явуулах бодлогын тухайд янз бүрийн таамаглал байдаг. Зарим судлаачид эх газрын Хятад Тайваны эсрэг цэргийн хүч хэрэглэнэ гэж бичсэн нь бий. Мөн өнгөрсөн оны 11-р

сард Гонконг, Японы мэдээллийн хэрэгсэл БНХАУ, Тайваныг зэвсгийн хүчээр чөлөөлөхөөр бэлтгэж байна гэсэн агуулгатай мэдээ тараасан билээ. Энэ нь бодот байдлыг харгалзан үзээгүй хэрэг юм. Ийм алхам хийх нь БНХАУ-ын шинэчлэл, нээлттэй эдийн засгийн бодлогод хохирол учруулах бөгөөд асуудлыг дэндүү олон улсын чанартай болгож байна. Тэгээд ч ЗХУ задарсантай уялдан олон улсын нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн, БНХАУ олон улсын харилцаанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэн, шинээр томъёолсон 4 зарчмынхаа дагуу гадаад бодлогоо явуулж буй үед Тайваны асуудлыг зэвсгийн хүчээр шийдвэрлэхийг хэрхэвч хүсэхгүй нь тодорхой.

Сүүлийн жилүүдэд БНХАУ Тайвантай эдийн засгийн талаар нягт хамтран ажиллахад ихээхэн анхаарал тавьж байна. Тухайлбал:

1. 1990 оны хавар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн Тайваны үйлдвэр, худалдааны бүлгийнхний төлөөлөгчидтэй уулзахдаа «Тайванаас хөрөнгө оруулах, тэдний тэргүүний техник технологийг ашиглан үйлдвэр байгуулахыг Хятад улс дэмжинэ»<sup>6</sup> гэжээ.

2. 1991 оны 5-р сард БНХАУ-ын Эдийн засгийн гадаад харилцаа, худалдааны Яамны сайд Хятад-Тайваны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай» Эх газар болон Тайван арлын эдийн засаг бие биеэ нөхөн гүйцээдэг бөгөөд худалдааны шууд харилцаа хөгжүүлэх нь хятад үндэстнийг нэгтгэхэд тус дөхөм үзүүлнэ.<sup>7</sup> гэж заалаа.

3. Өнгөрсөн оны 12-р сарын 16-нд Бээжинд «Тайваны хоолойн хоёр эргийн харилцааг эрхлэх байгууллага» байгуулав. Энэ нь иргэдийн зорчиж жуулчлах, харилцан ашигтай эдийн засгийн харилцааг тогтоох зорилготой бөгөөд Хятаддаа энэ чиглэлээрх гурав дахь байгууллага юм<sup>8</sup>.

4. Өнгөрсөн оны 11-р сард Сеулд нээгдсэн Ази, Номхон далайн эдийн засгийн зөвлөлийн гурав дахь уулзалтад оролцсон Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь: «Уг уулзалтад БНХАУ, Гонконг, Тайван гурав хамтран Хятадыг төлөөлөн оролцож байгаа нь эх орноо нэгтгэх хэрэгт харин ч тус дөхөм болно»<sup>9</sup> гэж мэдэгдсэн нь олон улсын эдийн засгийн байгууллагуудад Тайваны төлөөлөгчдийг оруулах нь «Хоёр Хятад улс» юм уу «Нэг Хятад, нэг Тайван улсын бодлого явуулж буй хэрэг хэмээн үзэж, эрс эсэргүүцдэг байсан урьдын байр сууриа өөрчилснийг харуулж байна.

5. Хятадын ерөнхий сайдын орлогч байсан Ли Сяньнянь 1992 оны 2-р сарын эхээр Фузянь мужийн радиогоор үг хэлэхдээ Тайван, Сянганд нэлээд шуугиан дэгдээж буй «Бүх Хятадын нийтийн зах зээл» байгуулах үзэл санаанд нааштай хандсан байна<sup>10</sup>.

Энэ бүхэн нь БНХАУ-ын зүгээс Тайвантай харилцахдаа эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааны үндсэн дээр улс төрийн шууд өргөн яриа хэлэлцээ хийж, улмаар нэгдэх бодлого баримталж буйг баталж байна.

#### **Эх газрын Хятадад хандах Тайваны хандлага**

1949 онд Чан Кайши өөрийн талынхны хамт Тайван арал дээр зугтаж очсоноос хойш өнөөг хүртэл БНХАУ-тай харилцахдаа Тайваны засаг захиргааны гол баримталж ирсэн зарчим бол «гурван үгүй» буюу ямар ч хэлэлцээ хийхгүй, ямар ч буулт хийхгүй, ямар ч хэлхээ холбоо тогтоохгүй гэдэг зарчим бөгөөд Гоминьданы Засгийн газрыг Хятадын хууль ёсны Засгийн газар, Тайван арлыг БНХУ-ын Төв засгийн газрын түр байрлах газар гэж үзсээр ирсэн юм. Тухайн үедээ Чан Кайши: «Бид болон дайсны хоорондох цорын ганц хэлхээ холбоо нь цус ба илд сэлэмний л холбоо юм»<sup>11</sup> гэж мэдэгдэж байсан билээ. 1975 онд Чан Кайши үгүй болж, хүү Зян Зинго суурийг нь залгамжилс-

наас хойш ч энэ зарчмыг хатуу баримталж байв. Харин 80-аад оны эхээр Зян Зинго олны шахалтад автаж, Тайванд ардчилах үйл явцыг дээрээс эхэлсэн бөгөөд 1987 оноос төрөл төрөгсөдтэйгөө уулзахаар эх газарт очихыг иргэддээ зөвшөөрсөн байна.

Зян Зиндогийн дараа 1988 онд дэд ерөнхийлөгч Ли Дэнхуэй арлын үндсэн хуулийн дагуу шууд ерөнхийлөгч болсон бөгөөд 1990 онд 6 жилийн хугацаатай ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон юм. «Тайваны асуудал»-ыг нааштай шийдвэрлэх, хоёр талын харилцааны хурцадмал байдлыг арилгах талаар Тайваны талаас хийсэн алхмууд чухамхүү Ли Дэнхуэй арлын улс төрийн тавцанд нэгдүгээр хүн болон гарч ирсэнтэй холбоотой. Тэрээр ерөнхийлөгчийн тангараг өргөхдөө: «Бээжингийн коммунист засгийн газартай дайсагналцахаа зогсооно. Эх газрын Хятадтай яриа хэлцээ хийхэд бэлэн байна. Яриа хэлцээ хоёр талын бүрэн эрхийн үндсэн дээр Засгийн газрын төвшинд явагдах ёстой. Бо лолцоотой үе ирмэгц бид эх орноо нэгтгэх асуудлыг эв зүйгээр хэлэлцэж эхэлнэ<sup>12</sup> гэж мэдэгджээ.

Гэхдээ Тайваны эрх баригчид хоёр талын хурцадмал байдал хангалттай зөөлрөөгүй гэдгээр шалтаглан одоо болтол шууд харилцаа тогтоохоос татгалзаж байна.

Тайваныханд эх газартай шууд өргөн харилцах, улмаар нэгдэхэд доорх үндсэн хүчин зүйл саад болж байгаа юм. Үүнд:

1. Хоёр талын улс төрийн өөр өөр үзэл баримтлал, байр суурь. Гомиьнданы тал ХКН-ыг дайснаа гэж үзсээр ирсэн боловч БНХАУ-ын төрийн тогтолцоо, дотоод бодлогын зарим асуудалд хандах тэс өөр хандлага.

2. Эдийн засгийн хөгжлийн эрс тэс ялгаатай байдал\*

	Тайвань	БНХАУ
Гадаад валютын нөөц (тэрбум долл.)	84	21
1 хүнд ноогдох ҮНБ, 1990 он	7990	325
2000 оны төлөв	13400	---
Экспортын хэмжээ (тэрбум долл.)	66,8	62,1
Гадаад худалдааны ашиг алдагдлын зөрүү (сая долл.)	10870	6270
Гадаад өр (тэрбум долл.)	0	45,4

\* 1991 оны байдлаар авсан болно.

Тайваны их сургуулийн хууль зүйн ухааны профессор Фу Куньчэн «Тайван НҮБ-д дахин элсэх тухай» хэмээх өгүүлэлдээ «...Одоо Хятад улс бие даасан хоёр хэсэгт хуваагдсан нь үнэн учир тус тусдаа олон улсын эрхзүйн үүрэг гүйцэтгэж байна. Иймд эх газрын Хятад хийгээд Тайван нь Холбооны засгийн газар буюу холбоот гүрний засгийг байгуулахаасаа өмнө Дэлхийн бусад улс оронтой бие дааж харилцах нь Зөв зүйтэй юм»<sup>13</sup> гэж бичжээ. Үндсэндээ энэ өгүүлэлд Тайваны эрх баригчдын бодлого бүрэн туссан бөгөөд тэдний үзэж байгаагаар Тайван эх газрын Хятад хоёр нэгдэх нөхцөл бүрдтэл гадаад дотоод бодлогоо тус тусдаа бие даан явуулж, олон улсын харилцаанд оролцож байх ёстой ба нэгдэх завсрын шат нь Холбооны засгийн газар байж болох юм.

Тайваны тал 1990 оны сүүлээс эхлэн Хятадтай харилцах харилцаандаа нааштай өөрчлөлт оруулах хэд хэдэн алхам хийгээд байна. Үүнд:

1. 1990 оны сүүлээр Хятадтай харилцах харилцааг зохицуулах Тайваны хоолойн солилцооны сан гэгчийг байгуулсан.

2. 1991 оны 5-р сарын 1-нээс эхлэн ХКН-ыг дайснаа гэж үзсэн 1947. оны Үндсэн хуулийнхаа заалтыг цуцалсны дээр коммунист Хятадыг чөлөөлөхийн тулд байлдааны бэлэн байдалд байх тушаалаа мөн цуцалжээ.

3. Тайваны тусгаар тогтноулах үзэл санааг Гомиьданы эрх баригчид эрс эсэргүүцдэг юм (Жишээ нь, Тайваны тусгаар тогтноулах хөдөлгөөний удирдагч Жан Санхуныг Тайванд ирэхийг хориглосон. Сөрөг ардчилсан дэвшлийн намын хөтөлбөрийг эрс шүүмжилдэг). Ерөнхийлөгч Ли Дэнхуэй 1991 оны 10-р сарын 25-нд Тайбэйн телевизээр үг хэлэхдээ: «Цөөн тооны хүмүүс иргэдээс санал хураах арга замаар «БН Тайван Улс» гэгчийг байгуулахыг оролдож байгаа нь хэсэг бүлэг хүмүүсийн хариуцлагагүй үйл ажиллагаа мөн»<sup>14</sup> гэжээ.

4. Арлынхантай хэлэлцээ хийх албан ёсны суваг бий болгох Хятадын саналыг Тайваны засаг захиргааны дарга Хау Пэйцун дэмжсэн бөгөөд тэрээр 1991 оны 11-р сарын 5-нд парламентдаа: «Энэ нь хоёр талын харилцааг хөгжүүлэхэд тун сайхан алхам болно»<sup>15</sup> гэж мэдээлсэн юм.

5. 1992 оны 3-р сард Тайваны эрх баригчид соёл, шинжлэх ухааны ажилтны уулзалтад өөрийн Засгийн газрын албаны хүмүүсийг оролцуулна гэдгээ мэдэгдсэн бөгөөд Тайбэйн зарласнаар Засгийн газрын Академийн ерөнхийлөгч Удаю тэргүүтэй төлөөлөгчид 5-р сард Бээжинд болох олон улсын физикчдийн семинарт оролцох ажээ. Энэ нь анхны албан ёсны айлчлал болно.<sup>16</sup>

Энэ бүхнээс үзэхэд Тайван нь эх газрын Хятадтай идэвхтэй хамтран ажиллахыг зорьж байгаа бөгөөд өнгөрсөн оны 12-р сард болсон анхны чөлөөт сонгуулиар Гомиьданы нам олонхын саналыг авсан болон тус намаас сонгогдсон ерөнхийлөгч 1996 он хүртэл төрийн эрхэнд байх зэргийг харгалзан үзвэл энэ бодлогод ойрын жилүүдэд ноцтой өөрчлөлт гарахгүй болов уу.

#### **«Хоёр Хятад»-д хандах их гүрнүүдийн бодлого**

«Тайваны асуудал» бий болоход дэлхийн дайны дараа их гүрнүүдийн зүгээс Хятадад явуулж байсан бодлого тодорхой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд одоо ч зохих хэмжээгээр нөлөөтэй байгаа билээ. Энд АНУ-ын байр суурийг онцлон авч үзэх хэрэгтэй юм.

БНХАУ-тай дипломат харилцаа тогтоох хүртлээ Вашингтон Тайбэйн дэглэмийг тууштай дэмжиж ирсэн юм. БНХАУ-тай 1979 оны 1-р сарын 1-нээс дипломат харилцаа тогтоосныхоо дараа ч Америкийн тал асуудалд хоёрдмол байр суурь баримталж иржээ. Тухайлбал, 1979 оны 4-р сарын 10-нд АНУ-ын конгресс Тайвантай харилцах хууль» гэгчийг баталж үүндээ: «Тайваны асуудлыг зэвсгийн хүчээр шийдвэрлэх аливаа оролдлогыг АНУ өөрийн үндэсний аюулгүй байдалд халдсан хэрэг гэж үзнэ»<sup>17</sup> гэж заажээ. Хэдийгээр АНУ Тайвантай албан ёсны дипломат харилцаагаа тасалсан боловч АНУ-д Умард Америкийн хэргийг хамаарах Тайваны зөвлөлдөх хороо, Тайванд Америкийг судлах төв гэдэг байгууллагууд байгуулагдсан бөгөөд эдгээр нь нэг ёсны элчин сайдын яамны үүрэг гүйцэтгэж байна.

Нөгөө талаар АНУ Тайваны асуудлаас болж дэлхийн тавцанд нөлөө бүхий БНХАУ-тай сөргөлдөхийг хүсэхгүй бөгөөд энэ нь ч бүрэн ойлгомжтой юм. Харилцаагаа муутгах бодолгүй байгаагийн нэг нотолгоо нь өнгөрсөн оны 5-р сард ерөнхийлөгч Буш БНХАУ-д суугаа АНУ-ын элчин сайд Ли Жеминг албан тушаалаас нь чөлөөлсөн бөгөөд Ли Жемин «АКН Тайваныг өөрийн эрх мэдлийн газар гэж үзэж байгаа нь бодот байдалд огт нийцэхгүй» гэж хэлсэн нь ийнхүү чөлөөлөх шалтгаан болжээ.

1985—1989 онд БНХАУ-д Америкийн элчин сайдаар сууж байсан Уинстон Лорд «Хятад ба АНУ» хэмээх өгүүлэлдээ: «...Засаг захиргаанд бие биеийнхээ ажлыг сольж авсан АНУ-ын өндөр албан тушаалын хүмүүсийн олонх нь сүүлийн 20 жилд Хятад-Америкийн гаргасан гурван хамтарсан мэдэгдлийг үг үсэгчлэн баримтлах, «Нэг Хятад улс» байх зарчимд үнэнч байхаа амлацгааж байгаа юм... АНУ Тайваны асуудлаарх бодлогодоо ноцтой өөрчлөлт гаргасан тохиолдолд Вашингтонтой харилцах харилцаагаа Бээжингийн аливаа удирдагч бүрэн таслах хүртэл бууруулна»<sup>18</sup> гэж бичжээ.

Бүхий л байдлаас үзэхэд АНУ «Тайваны асуудал»-ыг эв зүйгээр шийдвэрлэхийн төлөө байгаа нь харагдаж байна. Энэ бүс нутагт жинтэй нөлөө бүхий Орос, Япон хоёр улс уг асуудалд мөн прагматик байр сууринаас хандаж буй бөгөөд эдийн засгийн талаар Тайвантай хамтран ажиллах нь Хятад-Орос, Хятад-Японы хоорондын улс төр, эдийн засгийн харилцаанд хор хохирол учруулах ёсгүй гэж үзэж байгаа юм.

Бүс нутгийн нөлөө бүхий гурван их гүрэн ийнхүү аль аль нь «Тайваны асуудал»-ыг энх тайвны замаар шийдвэрлэхийн төлөө байгаа нь цаашдын үйл явцад эерэг нөлөө үзүүлж болох талтай.

### Дүгнэлт

Дээр өгүүлснээс үндэслэн дүгнэхэд Хятад-Тайваны харилцаа нь сөргөлдөөнөөс харилцан ашигтай хамтын ажиллагааны хэлбэрт шилжиж байна. Ойрын ирээдүйд хоёр талын харилцаа Засгийн газар хоорондын шууд харилцааны хэлбэрт шилжих төлөвтэй байгаа юм. «Бүх Хятадын нэгдсэн зах зээл» байгуулах үзэл санаа хэрэгжих шатандаа орох нь ойрын ирээдүйд болох гол үйл явдал болов уу. Энэ үйл явцыг түргэтгэхэд нэг талаас Тайваны экспортын барааны уламжлалт зах зээл хумигдах тийш хандаж байгаа болон эдийн засгийн бусад хүчин зүйл нөлөөлөх болно. Түүнчлэн дэлхий дахин дахь интеграцын үйл явц түргэсч байгаа нь нааштай нөлөө үзүүлж болох юм. Нэгдэхийн тухайд гэвэл энэ нь нэлээд цаг хугацаа шаардах биз ээ.

х х х

Монгол улсын гадаад бодлого урьдын баримталж ирсэн догматик, ерөөсгөл хандлагаас салж, нэг тулгуурт байдлаас олон тулгуурт байдалд шилжиж буй өнөө үед их гүрнүүдийн, ялангуяа өмнөд хөрш БНХАУ-ын гадаад бодлого, дипломат үйл ажиллагааг анхааралтай судлах нь цаг үеийн чухал шаардлага болон тавигдаж байна.

Зах зээлийн эдийн засагт шилжиж буй монголчууд БНХАУ-ын гадаад бодлогын нэг чухал объект болсон, Ази тив төдийгүй дэлхийн эдийн засагт нөлөө бүхий Тайвантай ч харилцах нь зайлшгүй билээ. Хятад-Тайваны харилцаа сайжирч байгаа нь Тайваны техник технологийг татан оруулах зэргээр эдийн засгийн салбарт хамтран ажиллах бодит боломжийг манай улсад нээж байна. Гэхдээ энэ нь Монгол улс болон БНХАУ-ын хоорондын харилцаанд хор хохирол учруулах ёсгүй бөгөөд Тайван арал нь БНХАУ-ын салшгүй нэгэн хэсэг юм гэдэг үндсэн дээр бид Тайвантай харилцах ёстой билээ.

1. Эхо планеты. 1989, № 43.
2. Энциклопедия Нового Китая. М., 1989, 185.
3. Мөн тэнд
4. Дипломатический словарь. Т. 1. 1984, 37.
6. Цаг үе, 1990. № 15.
7. Үнэн. 1991, № 74.
8. Бээжингийн радио (монгол хэлний нэвтрүүлэг). 1991. 12. 17.
9. Reuter: МОНЦАМЭ, Мэдээлэл, 1991, 11, 17, № 266,

10. Москвагийн радио. 1992. 02. 26.
11. Новое время, 1990, No 46.
12. Цаг үе. 1990, № 15.
13. Жун Гуан (Тайван): МОНЦАМЭ, Мэдээлэл. 1991. 10. 29, № 249.
14. Мөн Тэнд.
15. Reuter: МОНЦАМЭ. Мэдээлэл, 1991. 11, 07, № 257,
16. Reuter: МОНЦАМЭ, Мэдээлэл. 1992. 03, 24, № 69,
17. Дипломатический словарь. Т. I. 1984, 44—45,
18. Foreign affairs: МОНЦАМЭ. Мэдээлэл. 1989, № 327—329.

**Бусад ном зохиол**

1. Капустин Д. Т. Тайвань и Южная Корея в китайско-американских отношениях, 1980.
2. Капица М. С. БНХАУ: Гучин жилд гурван бодлого, 1984.